



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠮᠵᠢ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/206

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн хуулийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 16 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх ГАОНӨГ/202312025 дугаартай "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн хүрээнд Сургуулийн өмнөх боловсролын багш нарыг компьютержүүлэх ажлыг "Ай Ти Зон" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т олгосугай.

2.Техникийн тодорхойлолтыг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР